

ШИНЭ БАЙГУУЛЛАГА

**МОНГОЛЫН ХЯТАД
СУДЛААЧДЫН ХОЛБОО
БАЙГУУЛАГДЛАА****Л. Бэгзжав**

Монголын олон нийтийн үүсгэл санаачилгаар Монгол-хятадын найрамдлын нийгэмлэгийн дэргэд 1990 оны нэгдүгээр сарын 27-нд буюу МЭӨ 2637 оноос уламжилж ирсэн хятадын жарны он тооллоор цагаан морин жилийн шинийн нэгэнд Монголын хятад судлаачдын холбоо (МХСХ) байгуулагдлаа. Гарч байгаа шинэ он хүн бүрийн амьдралд шинэ хуудас нээж, тэдэнд аз жаргалын итгэл найдвар авчирна гэж Хятадад үздэг. Бэлгэ дэмбэрэлтэй энэ өдөр Монголын хятад судлаачдын холбоо байгуулагдсан нь хятад судалын шинжлэх ухаанд шинэ хуудас нээж буй төдийгүй, өнө эртний уламжлалт монгол, хятадын ард түмний найрамдлын бас нэг тэмдэглэлт үйл явдал боллоо.

Хүн төрөлхтний соёл иргэншилд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн агуу их хятадын ард түмний хэл, соёл, түүх, гүн ухаан зэрэг нийгмийн амьдрал, мэдлэгийн бүхий л хүрээг хамарсан хятад судлал шинжлэх ухааны нэгэн салбарын хувьд дэлхий дахинд эрч хүчээ авсаар байна.

Хүн ам нь манай гаригийн хүн амын 22 хувийг эзлэх, газар нутгийн хэмжээ нь ЗХУ-ыг үл оролцуулан европын 34 орны нутаг дэвсгэртэй бараглан тэнцэх хөгжиж буй социалист орон БНХАУ-ын олон улсын нэр хүнд, байр суурь, хөрш зэргэлдээ болон бусад олон оронтой тогтоосон найрамдал, хамтын ажиллагаа өдрөөс өдөрт хөгжиж байна. Төв, Дорнод Азийн төдийгүй дэлхийн том гүрнүүдийн нэг БНХАУ-тай олон мянган жилийн турш хаяа хатган, айл хөрш оршиж ирсэн БНМАУ хятад судлалын эртний уламжлал, баялаг өвтэй дэлхийн цөөн орны нэг билээ.

Эдүгээ хүртэл өрнө, дорнын олон оронд хараахан орчуулагдаагүй байгаа хятадын түүх соёл, уран зохиолын гайхамшигт дурсгал бичгүүдийг манай монголчууд өмнөх үеийн монгол нанхиадчидынхаа ачаар эх хэлээрээ уншиж байлаа. «Их Ляо улсын судар», «Алтан улсын судар», «Их Юань улсын судар» болон Күнзийн сургаал, түүнчлэн «Дөрвөн бичиг, таван ном» хэмээн алдаршсан Мэнзийн бичиг, Их суртахуй бичиг. Шүүмжлэл өгүүлэл, Ер дунд бичиг хийгээд «Ачлалт ном» «Засагт ном», «Шүлэглэлт ном», «Шажинт ном», «Зурхайт ном» болон тэдгээрийн тайлбар зэрэг олон монгол орчуулгыг дурьдаж болно, Хятадын төдийгүй дэлхийн уран зохиолын дурсгалт бичгүүдийн тоонд ордог «Хүйтэн уулын бичиг», «Гурван улсын үлгэр», «Тансан ламын баруун этгээд зорчсон тэмдэглэл», «Улаан асрын зүүд», «Эрт эдүгээ гийн гайхамшигт сайхан үзэгдэл хэмээх судар», «Жин Пин Мэй» бичиг зэрэг олон ном зохиол монгол хэлээр манай үед хүрч иржээ.

Монголын ард түмний хятад судлалын олон үеийн шилдэг уламжлалыг өвлөн уламжлах, хятад судлалыг эрчимтэй хөгжүүлэх, нанхиадач, хятад хэлний орчуулагч, ажил төрлийн хувьд БНХАУ-тай холбоо харилцаа бүхий байгууллага, хувь хүмүүсийг хүчийг нэгтгэх, улмаар монгол-хятадын найрамдал, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэх явдал шинээр байгуулагдаж буй МХСХ-ны зорилго юм.

Тус холбооны үйл ажиллагаа нь өмнөд хөршөөсөө сурах, тэдний туршлагыг амьдралын янз бүрийн салбарт нэвтрүүлэх, дэлхийн олон орны ижил төстэй зорилго бүхий холбоо, нийгэмлэг, хувь хүмүүстэй хамтран ажиллах, хоёр орны харилцаа, БНХАУ-ын социалист байгуулалтын өнөөгийн байдал, түүх соёл, утга зохиолоос монголын олон нийтэд танилцуулах, онол, практик, эрдэм шинжилгээний бага хурал, дугуй ширээний ярилцлага, лекц, мэдээлэл уулзалт хийх, хятад хэлний анхан шатны болон гүнзгийрүүлсэн сургалт явуулах зэрэг олон талт арга хэмжээ явуулахад чиглэнэ.

МХСХ-ны анхдугаар хурлаар холбооны дүрэм, хийх ажлын төлөвлөгөөг хэлэлцэж, холбооны тэргүүлэгчдээр 9 хүнийг сонгож батлав. Тус холбооны ерөнхийлөгчөөр БНМАУ-ын Гадаад явдлын Яамны ажилтан, хятад судлаач Х. Аюурзаныг сонгов.

Монгол, хятадын ард түмний харилцан ойлголцол, итгэлцийг бэхжүүлэх үйл хэрэгт Монголын хятад судлалын холбоо байгуулагдсан явдал урагшлуулагч алхам болох нь дамжиггүй. Эв найрамдлыг дээдлэх ариун үйлсэд анхны алхам багадахгүй. БНМАУ, БНХАУ хөрш хоёр орны хувьд сайн хөршийн ёсоор зэрэгцэн орших нь энх тайван, дэвшил хөгжлийн эрх ашигт нийцэж байна.

МОНГОЛЫН ЯПОН СУДЛАЛЫН ТӨВ

О. Хонгорзул

Япон улс эртний түүх, соёл, уламжлал, зан заншлаа эрхэмлэн хадгалж, эдүгээ шинжлэх ухаан, техник, эдийн засгийн хөгжлөөр гайхагдаж байгаа нь дэлхийн улс түмний анхаарлыг арга буюу татаж байна.

Сүүлийн үед дорнодахины ард түмний соёл урлаг, зан заншил, түүхийг дэлхийн олон оронд ихэд сонирхон судлах болов. Нэн ялангуяа япон судлал улс орон бүрт өргөжин тэлсээр байна. Үүний нэг илрэл бол манай оронд 1989 оны 7-р сард Монголын япон судлалын төв байгуулагдсан явдал юм.

Тус төвийн зорилго нь монгол, японы ард түмэн харилцан бие биеэ ойлголцох, түүх соёлоо гүнзгийрүүлэн судлахад тус дөхөм үзүүлэх, түүнчлэн дэлхийн бусад орны ижил төстэй байгууллагатай хамтран ажиллах, өөрийн орны судлаачдын хүчийг төвлөрүүлэн японы шинжлэх ухаан, техникийн ололт амжилтыг нарийвчлан судлаж нийгэмд өгөөжтэй, хүртээмжтэй зүйлийг судлан үйлдвэрлэлд нэвтрүүлэх, хамтын ажиллагааны шинэ, шинэ хэлбэрийг бий болгож ажиллахад оршино.

Монголын япон судлалын төв нь өнгөрсөн хугацаанд «Сузуки хаи биоин» хэмээх шүдний эмнэлэг, Улаанбаатарын шүдний төв эмнэлгийн хооронд зуучилж шууд холбоо тогтоолоо. Ингэснээр туршлага солилцох шууд боломжтой болов. Төв байгуулагдсаныг тохиолдуулан тус төвөөс «Япон орон, япончууд» хэмээх номын эхийг бэлтгэж Мон-